



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2026/034/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Ариунтуяа Утас: 70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Төлбөрийн акт	11
3.2 Албан шаардлага	11
3.3 Зөвлөмж.....	12
4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/	14
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагараа баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 154
танай _____ -ны № _____ -т

МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ч.УЛААНХҮҮ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллагийн талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мянгад сумын Засаг даргын тамгын газар нь Иргэдийнхээ хөгжлийн асуудлыг нэн тэргүүнд тавьж энэхүү зорилтын хүрээнд эрүүл мэнд, боловсрол, биеийн тамир спорт, соёл урлаг, нийгмийн хамгааллын бодлого, төлөвлөлтийг тусган хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулсан байна.

Тайлант онд хасах тодотгол хийсэнтэй холбоотой 32,974.2 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Мянгад сумын засаг даргын тамгын газарт 2025 онд хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр ухаалаг самбар 2 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг, chromebook 30

8426050348

ширхгийг ерөнхий боловсролын сургуулийн цахим ангид нийлүүлж, багш нар сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. ОНХО-аар 226,600.0 мянган төгрөгийн ковшийг хүлээн авсан, сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 36,640.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 286,437.7 мянган төгрөгийн гүний худаг, багийн төвүүдийн бярааз, контейнер, соёл амралтын хүрээлэн, шим ус ХХК-с 369,837.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр, тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө 8 зорилтын хүрээнд 61 арга хэмжээг төлөвлөн сумын Засаг дарга 98.8 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>146,643,858.70</u>	<u>169,481,451.70</u>
33	АВЛАГА	40,931,543.70	65,377,123.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	47,610.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	35,639,073.50	60,176,263.50
335	Бусад авлага	5,244,860.20	5,200,860.20
3351	Байгууллагаас авах авлага	24,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,220,860.20	5,200,860.20
34	УРЬДЧИЛГАА	20,500,000.00	20,500,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	20,500,000.00	20,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	85,212,315.00	83,604,328.00
354	Хангамжийн материал	49,810,315.00	48,202,328.00
35420	Аж ахуйн материал	49,810,315.00	48,202,328.00
35600	Мал амьтад	35,402,000.00	35,402,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,051,650,793.82</u>	<u>2,784,035,143.26</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,051,650,793.82	2,784,035,143.26
392	Биет хөрөнгө	2,011,060,793.82	2,743,745,143.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,819,451,848.46	2,632,485,550.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	-483,619,256.28	-747,434,266.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	159,380,950.00	385,980,950.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-86,894,484.16	-104,179,017.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	322,177,585.80	264,298,951.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-171,684,487.72	-140,835,608.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	177,081,308.00	174,842,630.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,842,340.92	-49,818,529.72
39209	Зам, гүүрийн байгууламж	432,103,735.00	432,103,735.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-85,094,064.36	-106,699,251.24
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,000,000.00	3,000,000.00
393	Биет бус хөрөнгө	40,590,000.00	40,290,000.00
39301	Програм хангамж	3,255,590.00	3,255,590.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,955,590.00	-3,255,590.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,290,000.00	40,290,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,198,294,652.52</u>	<u>2,953,516,594.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,887,380.00</u>	<u>32,974,237.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,887,380.00	32,974,237.40
413	Өглөг	1,887,380.00	32,974,237.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,887,380.00	00.00
4136	Бусад өглөг	00.00	32,974,237.40
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	16,841,447.40
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	16,132,790.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,196,407,272.52</u>	<u>2,920,542,357.56</u>

Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51	Засгийн газрын хувь оролцоо	2,196,407,272.52	2,920,542,357.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	561,660,058.00	561,660,058.00
51101	Өмч: - төрийн	561,660,058.00	561,660,058.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,249,035,988.08	1,991,241,240.12
51210	Өмнөх үеийн үр дүн	1,249,035,988.08	1,253,055,768.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	724,135,085.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	385,711,226.44	381,691,446.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,198,294,652.52</u>	<u>2,953,516,594.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,469,186,899.80	2,146,605,445.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	942,244,864.80	1,004,129,108.93
120	Нийтлэг татварын бус орлого	522,826,364.80	1,004,129,108.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	522,826,364.80	1,004,129,108.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,259,500.00	605,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	521,566,864.80	1,003,524,108.93
122	Тусламжийн орлого	419,418,500.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	419,418,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,526,942,035.00	1,142,476,337.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	631,496,635.00	85,527,463.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	67,245,913.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	631,496,635.00	18,281,550.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	895,445,400.00	1,056,948,874.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	895,445,400.00	1,056,948,874.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,929,683,097.31	1,422,470,360.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,929,683,097.31	1,422,470,360.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,903,456,583.82	1,345,000,596.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,432,430.29	776,025,967.04
210101	Үндсэн цалин	668,432,430.29	388,863,971.70
210102	Нэмэгдэл	00.00	340,119,926.48
210104	Урамшуулал	00.00	18,976,924.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	28,065,144.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,895,921.70	97,943,664.41
210201	Тэтгэврийн даатгал	81,895,921.70	65,840,664.41
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	8,025,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	4,012,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	4,012,800.00

Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	16,051,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,173,371.51	57,166,653.91
210301	Гэрэл, цахилгаан	5,009,811.51	9,753,345.91
210302	Түлш, халаалт	39,488,900.00	37,479,008.00
210303	Цэвэр, бохир ус	7,674,660.00	9,934,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,705,085.00	72,086,960.40
210401	Бичиг хэрэг	3,748,205.00	6,814,400.40
210402	Тээвэр, шатахуун	26,265,180.00	25,195,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,225,950.00	2,069,300.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	22,465,750.00	37,982,400.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	25,000.00
2105	Нормативт зардал	198,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	198,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,480,500.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	156,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,324,500.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	7,235,000.00	10,951,200.00
210702	Дотоод албан томилолт	7,235,000.00	10,951,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,200,070.00	3,885,040.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,946,650.00	3,213,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	132,060.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	00.00
210807	Газрын төлбөр	307,420.00	539,980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,029,136,205.32	326,941,110.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	862,145,065.00	89,726,351.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	583,500.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	166,407,640.32	237,214,759.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,226,513.49	77,469,764.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,527,000.00	800,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,782,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,699,513.49	76,669,764.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,699,513.49	76,669,764.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	539,503,802.49	724,135,085.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,673,000.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	50,673,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-50,673,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	488,830,802.49	724,135,085.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,972,713,765.50</u>	<u>1,132,506,697.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	425,678,000.00	605,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,259,500.00	605,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,259,500.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,259,500.00	605,000.00
120009	Бусад орлого	5,000,000.00	00.00
122	Тусламжийн орлого	419,418,500.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	419,418,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,547,035,765.50	1,131,901,697.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	651,590,365.50	74,952,823.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	56,671,273.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	651,590,365.50	18,281,550.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	895,445,400.00	1,056,948,874.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	895,445,400.00	1,056,948,874.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,972,713,765.50</u>	<u>1,132,506,697.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,972,713,765.50	1,132,506,697.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,910,848,178.51	1,030,499,742.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	661,212,020.80	773,482,911.45
210101	Үндсэн цалин	343,483,752.79	386,320,916.11
210102	Нэмэгдэл	232,705,849.46	340,119,926.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,215,973.75	00.00
210104	Урамшуулал	40,187,134.50	18,976,924.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,619,310.30	28,065,144.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,255,579.20	100,322,100.00
210201	Тэтгэврийн даатгал	58,028,579.20	68,219,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,599,300.00	8,025,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,171,800.00	4,012,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,436,300.00	4,012,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,019,600.00	16,051,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,845,900.00	58,585,307.91
210301	Гэрэл, цахилгаан	6,570,140.00	11,171,999.91
210302	Түлш, халаалт	38,047,800.00	37,479,008.00
210303	Цэвэр, бохир ус	8,227,960.00	9,934,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,561,206.51	15,923,100.00
210401	Бичиг хэрэг	2,764,400.00	2,436,050.00
210402	Тээвэр, шатахуун	14,423,500.00	10,037,050.00

Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,373,306.51	3,450,000.00
2105	Нормативт зардал	553,700.00	359,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	553,700.00	359,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,773,700.00	206,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	317,000.00	206,000.00
210604	Урсгал засвар	2,456,700.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	7,235,000.00	7,211,200.00
210702	Дотоод албан томилолт	7,235,000.00	7,211,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,830,530.00	5,820,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,051,110.00	4,898,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	132,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	867,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	307,420.00	539,980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,062,580,542.00	68,589,083.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,061,096,542.00	68,589,083.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,484,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,865,586.99	102,006,954.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,527,000.00	800,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,782,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,745,000.00	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,699,513.49	76,669,764.64
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,699,513.49	76,669,764.64
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	35,639,073.50	24,537,190.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,639,073.50	24,537,190.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058.00	00.00	1,249,035,988.08	1,810,696,046.08
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058.00	00.00	1,249,035,988.08	1,810,696,046.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	4,019,780.00	4,019,780.00

Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	561,660,058.00	00.00	1,253,055,768.08	1,814,715,826.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	4,019,780.00	00.00	-4,019,780.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	724,135,085.04	724,135,085.04
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	561,660,058.00	4,019,780.00	1,977,190,853.12	2,534,831,131.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,126,513,300.00	980,884,109.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,126,513,300.00	980,884,109.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,014,891,400.00	980,084,109.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	802,577,400.00	773,482,911.45
210101	Үндсэн цалин	411,729,800.00	386,320,916.11
210102	Нэмэгдэл	322,678,400.00	340,119,926.48
210104	Урамшуулал	37,756,400.00	18,976,924.00
210105	Гэрээт ажлын хөлс	30,412,800.00	28,065,144.86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,322,100.00	100,322,100.00
210201	Тэтгэврийн даатгал	68,219,100.00	68,219,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,025,800.00	8,025,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,012,800.00	4,012,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,012,800.00	4,012,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,051,600.00	16,051,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,595,500.00	58,585,307.91
210301	Гэрэл, цахилгаан	11,172,000.00	11,171,999.91
210302	Түлш, халаалт	37,487,500.00	37,479,008.00
210303	Цэвэр, бохир ус	9,936,000.00	9,934,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,376,000.00	15,707,100.00
210401	Бичиг хэрэг	2,908,200.00	2,436,050.00
210402	Тээвэр, шатахуун	15,756,900.00	9,821,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,710,900.00	3,450,000.00
2105	Нормативт зардал	683,200.00	359,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	683,200.00	359,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,010,200.00	206,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	494,600.00	206,000.00
210604	Урсгал засвар	1,515,600.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	8,583,600.00	7,211,200.00
210702	Дотоод албан томилолт	8,583,600.00	7,211,200.00

Мянгад сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,743,400.00	5,820,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,574,400.00	4,898,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	346,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	225,000.00	132,060.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	34,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	733,700.00	250,000.00
210807	Газрын төлбөр	830,300.00	539,980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,788,300.00	18,389,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	109,788,300.00	18,389,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,833,600.00	800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,833,600.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,833,600.00	800,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,126,513,300.00	980,884,109.36
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,063,066,700.00	980,279,109.36
132001	Орон нутгийн төсвөөс	1,063,066,700.00	980,279,109.36
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	63,446,600.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	62,841,600.00	00.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	50,415,633.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	50,415,633.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,415,633.00
2104	Хангамж, бараа материалын зардал	216,000.00
210402	Тээвэр, шатахуун	216,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,199,633.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,199,633.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,415,633.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,415,633.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,134,083.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,281,550.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 57,210.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 4,624.8 мянган төгрөгийн бүртгэл тайлангийн алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг 4,019.8 мянган төгрөгөөр бууруулах бичилтийг орхигдуулсан
- Үндсэн үйл ажиллагааны орлогыг данс андууран улсын төсвийн санхүүжилтээр бүртгэсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д ‘аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх’ заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан. Шалгагдагч байгууллагаас тайланд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрч залруулсан санхүүгийн тайланг ирүүлсэн болно.

Залруулагдаагүй 18,435.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 18,435.4 мянган төгрөгийн 4 зөрчил¹ илэрснээс, 400.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 18,035.4 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: Тус байгууллагын нягтлан бодогч 2025 оны 9 дүгээр сард жирэмсэн амаржсаны амралттай үед түр орлон хавсарч ажиллаж байсан нягтлан бодогчид түлшний хөнгөлөлтийг 500.0 мянган төгрөгөөр олгосныг ажилласан саруудад ноогдохоор тооцон 400.0 мянган төгрөгийг түр хавсран гүйцэтгэсэн нягтлан бодогчоос гаргуулан үндсэн орон тооны нягтлан бодогчид олгох алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална ", 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

3.2.1 Нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. Өмнөх оны аудитаар зөвлөмж өгсөн ч хэрэгжээгүй нь нягтлан бодогч хяналтыг хэрэгжүүлээгүй, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалын хавсралтын 2.1-д "Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1. Цалингийн нэмэгдэл, урамшуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын нэр бүхий 3 ажилтанд үндсэн орон тооны бус ажил үүргийг гүйцэтгэсэн ажилд ажил хавсруулсан 40 хувийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.4-т “жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч, тодорхой хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх”, гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан орон тооны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, ажил хавсарсны нэмэгдлийг 40 хувийг олгохыг зогсоох

3.3.2. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Он дамжсан, насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газартай 6,304.4 мянган төгрөгийн өвс, тэжээлийн нийлүүлэлттэй холбоотой авлага, өглөгийн тооцоо нийлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т “хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Он дамжсан насжилт өндөртэй авлага, өглөгийг барагдуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/МЯНГАН ТӨГРӨГӨӨР/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Нягтлан бодогч Э.Номин нь жирэмсний болон амаржсаны амралтыг 2025 оны 9 дүгээр сараас авсан бөгөөд тухайн ажилласан хугацаанд ногдох түлшний хөнгөлөлтийг түр ажил хавсарч байсан Д.Баярмаагаар төлүүлэн нөхөн олгох	1	400.0	1	400.0						
Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан. Өмнөх оны аудитаар зөвлөмж өгсөн ч хэрэгжээгүй	1	11,731.0			1	11,731.00				
Үндсэн орон тооны бус ажил үүргийг хавсруулан 40 хувийн нэмэгдэл олгосон 3 албан хаагчийн ажил хавсарсны нэмэгдлийг зогсоох	1	0					1	0		
Насжилт өндөртэй авлага барагдуулаагүй, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газартай 6,304.4 мянган төгрөгийн өвс, тэжээлийн нийлүүлэлттэй холбоотой авлага, өглөгийн тооцоо нийлээгүй, зөрүүтэй	1	6,304.4					1	6,304.40		
	4	18,435.4	1	400.0	1	11,731.00	2	6,304.40	0	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			